



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Иргэний эрх зүйн маргаан¹)

ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХДАА ХҮСЭЛ ЗОРИГ БАЙГААГҮЙ НӨХЦӨЛД ГЭРЭЭ БАЙГУУЛАГДСАН ГЭЖ ҮЗЭХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/00227

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээв.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч хуулийн этгээд хариуцагч иргэнд холбогдуулан зээлийн гэрээний үүрэгт 20,015,233.27 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан. *Ш.Б болон хамтран зээлдэгч болох хариуцагч нар 15,500,000 төгрөгийн цалингийн зээлийг жилийн 15,6 хувийн хүүтэйгээр, 60 сарын хугацаатай нэхэмжлэгчээс зээлсэн.* Гэвч Ш.Б нь нас барсан ба зээлийн төлөлт хийгдээгүй учир хамтран зээлдэгч болох хариуцагч төлөх ёстой гэжээ. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нэхэмжлэлийг эс зөвшөөрч, хариуцагч нь тэтгэмжээс өөр ямар ч орлогогүй, *сахрын дутагдал өвчнөөр оношлогдож, яваандаа тархины хатангиршилтай болж ой санамж муу, мартамхай болсон буюу 80 хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай тул зээлийг хамтран хариуцах үндэслэлгүй гэж маргажээ.*

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүх:** Нэхэмжлэгч хуулийн этгээдийн Иргэний хууль (2002 он)-ийн 451 дүгээр зүйлийн 451.1², 453 дугаар зүйлийн 453.1³-д заасныг үндэслэн хариуцагч иргэнээс 20,015,233.27 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.
- Давж заалдах шатны шүүх:** Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, 453 дугаар зүйлийн 453.2⁴-

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/10600?daterange=2024/01/01%20-%202024/12/09%20&id=3&court_cat=1&bb

² Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1 “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ”

³ Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.1 “Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй”

⁴ Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.2 “Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр



т заасныг баримтлан хариуцагч иргэнээс 20,015,223.27 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч хуулийн этгээдэд олгохоор шийдвэрлэжээ.

3. **Хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол:** Давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ зээлийн гэрээнд огт дүгнэлт хийлгүй буюу хариуцагчийг буцаан төлөх чадвартай эсэхэд дүгнэлт өгөөгүй. Хариуцагч зээл авахдаа ямар эрх эдэлж, үүрэг хүлээснээ мэдэхгүй байгаагаас гадна хүсэл зоригоо илэрхийлж гэрээ хэлцэл хийх бүрэн чадамжгүй хүн гэдэг нь биеийн хэлэмжээс нь харагддаг. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.
4. **Хяналтын шатны шүүх:** Хариуцагч нь 80 хувийн хөдөлмөрийн чадварын алдалттай группт байдаг бөгөөд түүний групп тогтоолгосон өвчний байдлаас үзэхэд хүсэл зоригоо бүрэн илэрхийлж чаддаг байсан эсэх нь эргэлзээтэй. *Хариуцагчийг эрх зүйн чадамжгүйд тооцоогүй ч өөрийгөө бүрэн дүүрэн илэрхийлэх чадваргүй талаар маргаж эрүүл мэндийн байдлыг илэрхийлсэн баримт гаргасан байхад зээлийн гэрээ байгуулах үндэслэл болсон зээл авах хүсэлт, зээлийн хувийн хэрэг зэрэг шаардлагатай баримтыг нэхэмжлэгч гаргаж, шаардлагаа нотлоогүй нь* хариуцагч гэрээг хүсэл зоригийн үндсэн дээр байгуулаагүй гэх дүгнэлтэд хүргэж байна.(11.5)⁵ Гэрээнд гарын үсэг зурсан нь хүсэл зоригийн илэрхийлэл мөн боловч хүсэл зориг байгаагүй нөхцөлд гэрээг байгуулагдсан гэж үзэх боломжгүй бөгөөд *хэлцлийн субъектив шинж болох “хүсэл зориг” байхгүй тохиолдолд гэрээг байгуулагдсан гэж үзэхгүй.*

---oOo---

гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй. Энэ заалт зөвхөн хөдлөх эд хөрөнгөнд хамаарна”

⁵ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.